



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Г “Моннис даатгал” ХХК-ийн даатгалын Г
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, Хорооны 2008 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам”-ын 2.1.1 дэх заалт, “Моннис даатгал” ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн АБ121 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Моннис даатгал” ХХК-д олгосон даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Моннис даатгал” ХХК-ийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийлгэхийг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах Татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлж ажиллахыг Тамгын газар /П.Алтан-Од/-т даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000912